

Living the Lotus 1

Buddhism in Everyday Life

2026
VOL. 244



Монголын Рисшо Косей Кай салбар
“Бурхан багшийн гэгээрсэн өдрийн ёслол” 2025.12.07

Living the Lotus
Vol. 244 (2026.01)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Миязава Кэнжигээс суралцах нь -1

Өргөнөөр харах ба бодь сэтгэл

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Галактикаар сэтгэж амьдрах

Та бүхэнд шинэ оны мэнд дэвшүүлье.

2026 он дэлхий дахинд амар амгалан түгэн дэлгэрэх эргэлтийн жил байгаасай хэмээн залбирч, өдөр бүрийг нандигнан бурхны үйлд хичээн шамдацгаая.

Үүний тулд бид бүхний санаж явбал зохих нэгэн шүлэг одоогоос яг 100 жилийн өмнөх хаврын эхэн сард Японы Иватэ мужийн Ханамаки хотод бичигдсэн байдаг.

“Даян дэлхий энх тайван болоогүй цагт хувь хүний аз жаргал байх боломжгүй. Би хэмээх ухамсар яваандаа хамт олон, нийгэм, сансар огторгуй болж тэлдэг. Энэ бол эртний гэгээнтүүдийн замнал, зааж сургасан зам мөр бус уу? Дэлхийн шинэ эрин үе бол нэг ухамсартай нэгэн бүхэл организм бүхий орчлон ертөнц байх учиртай. Зөв, хүчтэй амьдрана гэдэг нь галактикийг дотроо төсөөлж, сансар огторгуйн хуулийн дагуу амьдрах явдал. Хамтдаа дэлхийн жинхэнэ аз жаргалыг хайж олцгооё. Зам мөрийг эрэлхийлэх нь өөрөө зам мөр билээ.” (Ноомин гэйжүцү гайрон кооёо/ «Тариачны урлагийн ерөнхий онол»)

Энэ бол “Галактикийн төмөр замаар аялсан нь” хүүхдийн зохиол, “Бороонд ч ажрахгүй” шүлгээрээ алдартай Миязава Кэнжи гуайн үг юм. Энэ жил түүний мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаа ба өнөөгийн дэлхий ертөнцийн байдлыг харахад дээрх шүлэг бидэнд чухал зүйлийг сануулж байна.

Би сансар огторгуйгаас харагдах усан гариг болох дэлхийн талаар, дэлхий хэмээх сансрын хөлөгт суусан хамаг амьтан бүхний амь насыг хайрлаж хүндэтгэхийн чухлыг үе үе дурдаж байсан. Гэтэл Миязава гуай бүр галактикийн хэмжээнд сэтгэж байсан ба бид түүний ийм өргөн уудам оюун санааны цар хүрээ, билиг билгүүнээс суралцаж, өөрийн болон бусдын аз жаргалын талаар илүү өргөн хүрээнд авч үзэж, үйлдэл хийх нь бидний үүрэг билээ.



Мөн энэ үг бол Иватэ мужийн ахлах сургууль (Ханамаки хөдөө аж ахуйн сургууль) дээрх хүн үр бүтээмжтэй газар тариалан эрхэлж амьдрах арга ухаан, үндсэн ухагдахууны талаарх лекцийн нэг хэсэг тул хүүхэд залуусын сэтгэл зүрхэнд ийм ухамсрыг суулгах нь “хүн бэлдэх” үндсэн чухал зүйл гэж бодогдож байна.

“Бороонд ч ажрахгүй” шүлгийн дэвтэр бол судар

Миязава Кэнжи гуай Лянхуа судрын гүнзгий сүсэгтэн байсан гэдгийг та бүхэн мэднэ. Лянхуа сударт айлдсан Нэг хөлгөний сургаал, мөнх амь нас гэсэн ухагдахууныг тэрээр шүлэг, өгүүллэгээрээ дамжуулан түгээсэн гэж би боддог. Гэхдээ тэрбээр “бусдыг өөрчилж гэгээрүүлье гэж огт боддоггүй” гэж хэлснийхээ дагуу бусдад зааж сургахын төлөө шүлэг зохиол бичдэг байгаагүй. Зүгээр л дэлхий ертөнц энх амгалан байгаасай, хүн бүхэн аз жаргалыг олоосой хэмээн залбирч, өөрийнхөө итгэл үнэмшлийг байгаагаар нь шулуухан илэрхийлдэг байсан юм.

Гэхдээ түүний шүлэг, зохиолыг уншсан хүн өөрийн эрхгүй бусдыг энэрэхийн сайхныг ухаарч, шунал, уур уцаарын мунхагаа анзаарч, амь нас богинохон боловч мөнх оршдог гэдгийг мэдэрдэг учраас л түүний бүтээл он удаан жил хайрлан хүндлэгдэж, үзэл санаа нь хүлээн зөвшөөрөгдсөөр ирсэн. Энэ бол “өөрөө итгэж байж бусдыг дагуулна” гэсэн сүсэг бишрэлт хүмүүний дүр төрх билээ. Бид ч гэсэн ажил алба, гэр орны ажил, хүүхэд өсгөхдөө гэгээн цагаан сэтгэлээр бодисатва хүн шиг байхыг зорин бусдыг сэтгэлийн гүнээс энэрэн хайрлаж, ойлгодог хүн болох хэрэгтэй.

Түүний алдарт “Бороонд ч ажрахгүй” шүлгийг уншихаар надад судар уншиж буй мэт сэтгэгдэл төрдөг. Энэ шүлгээ бичиж тэмдэглэсэн дэвтрийнх нь эхэнд судрын “Бясалгал үйлдэн гэгээрэх замууд” хэсэг бичигдсэн байдаг ба үргэлжлүүлээд судрын “Залбирал” хэсгийг илэрхийлэх мэт “Намо мёо хоо рэн гэ кёо” тарнийг голд нь бичиж, эргэн тойронд нь дөрвөн их бодисатва (дээд үйл, хязгааргүй үйл, ариун үйл, амарлингуй үйл) байрлах хот мандалын хураангуй зураг байдаг нь яг л манай нийгэмлэгийн судрын бүтэц мэт. Дараа нь үргэлжлэх өөрийнх нь тангарагын үг, “Бороонд ч ажрахгүй” шүлэг нь яг л судрын сургаал мэт сэтгэл зүрхэнд минь уусан шингэдэг билээ.

Би өмнө энэ шүлгийг Миязава гуайн энгийн ойлгомжтой илэрхийлсэн “Насад зэвүүцэхгүй бодисатва бүлэг” гэж хэлж байсан. Дараа сард тус шүлгэнд өгүүлсэн бодисатва хүний хандлага, оюун санааны талаар дахин өгүүлэх болно.

«Косей» сэтгүүл, 1-р сарын дугаараас





Сэтгэлийн минь анд нөхөр Миязава Кэнжи

Маэда Такаши

Та бүхэнд шинэ оны мэнд хүргэе. Намайг Маэда Такаши гэдэг. Энэ жилээс РКК Олон улсын хэлтсийн даргын үүргийг хүлээн авч, та бүхэнтэй танилцаж байгаадаа баяртай байна.

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа “Дэлхий дахинд амар амгалан түгэн дэлгэрэх эргэлтийн жил байгаасай” гэсэн хүсэл залбиралаа бичжээ. Мөн Миязава Кэнжигийн үзэл санаа, амьдрахуй бол өнөөгийн бидэнд үлдээсэн нэн чухал сургамж хэмээн өгүүлсэн байна.

Би залуу байхаасаа л “Бороонд ч ажрахгүй” шүлэгт их дуртай байсан. Одоо ч гэсэн өдөрт 3-аас дээш удаа уншдаг ба Миязава Кэнжигийн үзэл санааг өөртөө шингээн тунгаах үүднээс үүнийг олон жил үргэлжлүүлж байна. Энэ хэвшлийн ачаар шүлгийн үгс өөрийн мэдэлгүй сэтгэлд буудаг болж, бага ч болов хүмүүсийг баярлуулж амьдардаг болсон юм болов уу гэж боддог. Миязава гуай тус шүлгээ хэвлэлийн цаас биш биенээсээ салгадаггүй тэмдэглэлийн дэвтэртээ бичсэн байсан нь цаанаа гүн утга учиртай болов уу.

Нивано ерөнхийлөгч, “Тэрээр Лянхуа судрын үзэл санааг шүлэг, өгүүллэгээрээ дамжуулж байсан хэдий ч, бусдыг өөрчлөх гэсэн санаа байгаагүй” гэж бичсэн байсан. Хэрэв бид бусдыг ойлгож, бодисатва хүнийг төрүүлдэг тийм амьдралаар амьдардаг бол үүнээс илүү гайхамшигтай амьдрал гэж үгүй биз ээ. Та бүхэн ч гэсэн өөрийн гэсэн онцлог чанараараа бусдад амар амгаланг мэдрүүлж амьдраарай. Энэ жил хамтдаа урагш алхацгаая.



Маэда дарга Бангладеш салбарын шинэ тэргүүн томилох ёслолд оролцов
(баруун гар тал) 2025.12.13,




Бангладеш салбарын шинэ тэргүүн томилох ёслолын дурсгалын зураг

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp